



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024-05-08 № 01/788
танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичгийг
хянасан тухай**

Танай газраас зарласан “Орон нутгийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах теле камерын систем (Босоо тэнхлэг)” ХЗДХЯ/20240102008 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хянан үзлээ.

1. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.7-т “Санал болгож байгаа хурд хэмжигч төхөөрөмж нь Монгол Улсын стандарт хэмжил зүйн байгууллагаар баталгаажсан хэмжих хэрэгслийн загварын баталгааны гэрчилгээтэй байх шаардлагатай.” гэж, ТШЗ 19.3.1.2-т “Хэмжил зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу тендерт оролцогч байгууллага нь санал болгож байгаа тээврийн хэрэгслийн хурд хэмжигч төхөөрөмжийг Стандарт хэмжил зүйн газраас олгосон Монгол Улсад импортлох, суурилуулах албан ёсны зөвшөөрөлтэй байх.” гэж тус тус заасан байна.

Хэмжил зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.” гэж, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 125 дугаар тушаалаар батлагдсан “Шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгслийн жагсаалт”-ын 03.002-т “Тээврийн хэрэгслийн хурд хэмжигч” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн 19.1.7 дахь шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа Хэмжил зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 125 дугаар тушаалыг тус тус баримталсан байх тул өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна.

2. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.6-т “Захиалагч байгууллагад санал болгох программ хангамж бэлэн ажилладаг байх. Туршилтын болон хөгжүүлэлтийн шатанд ажиллаж байгаа программ хангамжийг саналд ирүүлэхгүй байх” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Захиалагч техникийн чадавх

болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.” гэж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-т “Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардсан бол холбогдох шаардлагыг тусгана.]” гэж тус тус заасан байна.

Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.6-т заасан шалгуур үзүүлэлт нь техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох баримт бичигт хамаарахгүй байх тул захиалагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.3.1.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл” ТШЗ 19.3.2-т “Зураг төсөл боловсруулах компани нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд: ЗТ-2.1...ЗТ-3.1...ЗТ-4.1...ЗТ-6.4...гадна салбар шугам сүлжээний зураг төсөл. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-т “Гэрээний үүргийг гүйцэтгэхэд хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн ТШЗ 19.3-т “Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана., гэж 19.4-т “ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.” гэж тус тус заасны дагуу боловсруулсан байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

4. Тендерийн баримт бичгийн багц 1-ийн “Орон нутгийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах теле камерын систем (босоо тэнхлэг) нэвтрүүлэхэд шаардлагатай систем, тоног төхөөрөмж худалдан авах ажлын техникийн тодорхойлолт”-ыг тендерийн үнэлгээний хороо холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, захиалагчаар батлуулсан байна.

Техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хяналтын цэгийг бага зардлаар камержуулах, цаашид өргөтгөж, хөгжүүлэлт хийх боломжтой, хиймэл оюун ухаанд суурилсан, ухаалгаар удирдах, хянах, мэдээллийн сан байгуулж өгөгдөл дээр ажиллах дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, арга ажиллагааг нэвтрүүлэх үндсэн зорилготойгоор боловсруулсан гэж захиалагчаас ирүүлсэн тайлбарт дурдсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар,

түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.” гэж, “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын санамжид “Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.” гэж тус тус заасан байна.

Захиалагчаас 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 3/2257 дугаартай албан бичгээр ирүүлсэн тайлбар, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлээс үзэхэд багц 1-ийн Техникийн тодорхойлолт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.6-т холбогдох өөрчлөлтийг оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

Холбооно: 011-33333333
Хаяг: Улаанбаатар
Утас: 011-33333333